



Аудитын код: САГ-2018/26/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Монгол улсын ерөнхий аудиторын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунбилэг

Утас: Цахим хаяг: oyunbilegs@audit.gov.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Хосжаргал

Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn

Аудитор Б.Сэржмядаг

Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

Аудитор П.Амарсанаа

Утас: 261628 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын хураангуй тайлан	2
2	Аудитын гэрчилгээ	7
3	Аудитын тайлан	9
3.1	Оршил	9
3.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг хариуцлага	9
3.3	Байгууллагын зорилго үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	10
3.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	11
3.5	Дотоод аудит	12
3.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	13
3.7	Шилэн дансны мэдээлэл	13
3.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	14
3.9	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	14
3.9.1	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал	14
3.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал	15
3.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	17
3.11	Завсрын аудитаар авч үзэх асуудлууд	18
3.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	18
3.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл тайлбар	19
3.15	Зөрчилгүй санал дүгнэлт	19
3.16	Аудитын үр өгөөж	19
4	Менежментийн захидал	20
4.1	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчлийн талаар	21
4.2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар	21
4.3	Үндсэн хөрөнгийн талаар	22
4.4	Авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар	22
5	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	23
5.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	23
5.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	24
5.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	25
5.4	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	26
5.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	27
5.6	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	29
6	Зөрчлийн жагсаалт	30
6.1	Төлбөрийн акт	31





**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД Ж.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2018. 04. 25 № 1022
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



\\10.10.10.20\Bichg_Kheregi_Tawsan_Bichg\2018\0425\AS111.Docx

070496

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3 Аудитын тайлан

3.1 Оршил

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн авлага, цалингийн ангилал, харьяа газруудад илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

3.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (цаашид УСНББОУС гэх), түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 04 дүгээр сарын 5-наас 2018 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал, аудитор Б.Сэржмядаг, П.Амарсанаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 04/1432 тоот албан бичгээр буюу Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.



3.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Зам, тээврийн хөгжлийн сайд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар тогтоосон дор дурдсан асуудлуудын бодлого төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:


- Авто замын асуудал;
- Авто тээврийн асуудал;
- Төмөр замын тээврийн асуудал;
- Иргэний нисэхийн асуудал;
- Далай ашиглах болон усан замын тээврийн асуудал;
- Тээврийн тогтолцоог хөгжүүлэх бодлого, зохицуулалт;
- Салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудал;
- Агаарын бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудал зэрэг болно.

Зам, тээврийн хөгжлийн сайд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Зам, тээврийн хөгжлийн яам тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт 1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаар чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2017 оны зорилтот түвшин	Биелэлт	
Авто зам				
25.1	25.1.1	Байнгын ашиглалтад оруулах авто замын нийт хүчин чадал /км/	457.4	447.7
	25.1.2	Байнгын ашиглалтад оруулах гүүрийн нийт хүчин чадал /урт метрээр/	422.5	654.3
	25.1.3	Урсгал засвар, арчлалт хийх авто замын нийт хүчин чадал /км-ээр/	12917	12917
	25.1.4	Урсгал засвар, арчлалт хийх гүүрийн нийт хүчин чадал /урт метрээр/	13751.6	13751.6
	25.1.5	Эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны төслийн тоо	6	6
	25.1.6	Лабораторийн туршилт, шинжилгээний дүгнэлтийн тоо	600	2018
	25.1.7	1000 км ² нутаг дэвсгэрт ногдох авто зам /өмнөх оны суурь үзүүлэлтээс өсгөх хувь, хүрэх бодит үзүүлэлт/	13.0-оос доошгүй, 1.2-т хүргэх	7 хувиар буюу 0.31 км-ээр өссөн
Авто тээврийн хяналт, зохицуулалт, нийтийн тээвэр				
25.2	25.2.1	Авто тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоог хийх /үзлэгт хамрагдах хувь/	85	58.9
	25.2.2	100 000 хүн амд ногдох зам, тээврийн ослоос шалтгаалсан нас баралтыг бууруулах /өмнөх оны суурь үзүүлэлтээс бууруулах хувь/	15.0-аас доошгүй	15.3
	25.2.3	Зорчигч эргэлт /өмнөх оны суурь үзүүлэлтээс өсгөх хувь/	5.0-аас доошгүй	14.7
	25.2.4	Ачаа эргэлт /өмнөх оны суурь үзүүлэлтээс өсгөх хувь/	6.0-аас доошгүй	49.5
25.3	Төмөр зам			



Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

	25.3.1	Богдхан төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл боловсруулах /ажлын гүйцэтгэл хувиар/	10	30
	25.3.2	Таван толгой–Гашуун сухайт чиглэлийн 267 км төмөр зам барих /ажлын гүйцэтгэл хувиар/	60	52
	25.3.3	Хөөт-Бичигт чиглэлийн 222 км төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл боловсруулах /ажлын гүйцэтгэл хувиар/	30	100
	25.3.4	Шивээхүрэн-Сэхээ чиглэлийн 13 км боомтын төмөр зам барих /ажлын гүйцэтгэл хувиар/	100	30
	25.3.5	Эрдэнэт-Овоот чиглэлийн 581 км урт төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл боловсруулах /ажлын гүйцэтгэл хувиар/	30	70
	25.3.6	Зүүнбаян-Ханги чиглэлийн 281 км төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл боловсруулах /ажлын гүйцэтгэл хувиар/	10	50
	25.3.7	Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх МОН 2719/0240 төслийн барилгын ажил /ажлын гүйцэтгэл хувиар/	80	80
	Агаарын тээвэр			
	25.4.1	Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо /мянгаар/	96.6	111.1
	25.4.2	Буулт, хөөрөлтийн тоо /мянгаар/	6.6	6.8
	25.4.3	Ачаа тээвэрлэлт /мянган тонн/	6.3	5.3
25.4	25.4.4	Зорчигч тээвэрлэлт /мянган хүнээр/	900	1231.9
	25.4.5	Хөшигийн хөндийн олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих /ажлын гүйцэтгэл хувиар/	100	99.2
	25.4.6	Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх	орлогыг бүрэн төвлөрүүлсэн байх	102
	Зам, тээврийн бодлого, удирдлага			
25.5	25.5.1	Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх	орлогыг бүрэн төвлөрүүлсэн байх	100

Эх сурвалж: Зам, тээврийн хөгжлийн яам

Мөн Төсвийн тухай хуульд зааснаар 5 хөтөлбөрийн хүрээнд 11 арга хэмжээ төлөвлөснөөс 97.3 хувийн биелэлттэй ажилласан байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж баримтжуулсан.


3.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, /УСНББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай болон, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Зам, тээврийн хөгжлийн сайдын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод аудитын талаарх гол асуудал, дүгнэлтийг тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримтлагдсан байдлаар аудитын 29 хяналтын сорил болон нарийвчилсан горимыг гүйцэтгэж баримтжууллаа. /ТАБ-СТА-В-3/



Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Зам, тээврийн хөгжлийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2012 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэхгүй байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлал
- Сангийн сайдын баталсан заавар, журмууд
- Төсвийн орлого, зардлын эдийн засгийн ангилал
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шинээр гарсан бодлого шийдвэр
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг асуудлууд болно.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг гүйцэтгэлээ.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэдэг “Э-тайлан” програм ашиглажээ.

3.5 Дотоод аудит

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд хэвийн гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод аудит үр нөлөөгүй гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Зам, тээврийн хөгжлийн яамны Дотоод аудитын хороог салбарын сайдын 2015 оны 141 дүгээр тушаалаар 9 гишүүн, хараат бус 2 гишүүнтэйгээр баталсан байна. Мөн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2013 оноос шинэ бүтэц зохион байгуулалтаар 25 орон тоогоор ажилладаг ба үүний 16 ажилтан Зам, тээврийн хяналтын хэлтэст харьяалагддаг байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд удирдамжийн дагуу тайлант онд нийт 8 хяналт шалгалт хийж 5 зөвлөмж, 3 албан шаардлага, 2 төлбөрийн акт тогтоож биелэлтийг дүгнэн ажилласан байна.

Хүснэгт 2. Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	8
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	8
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	11
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо
		Дүн (сая.төг)
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо
		Дүн (сая.төг)
6	Тоо	2

01

ТӨРИЙН 153 ДИЙН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

	Тогтоосон төлбөрийн актын	Дүн (сая.төг)	889.2
7	Өгсөн албан шаардлагын	Тоо	3
		Дүн (сая.төг)	15,119.9

3.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Зам, тээврийн хөгжлийн сайд 2017 онд хэрэгжүүлэх 5 хөтөлбөр 11 арга хэмжээ түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хуулиар Зам, тээврийн хөгжлийн сайдын төвлөрүүлэх орлогын хэмжээг 145,515.3 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 149,229.9 сая төгрөгийг бүрдүүлжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчид батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж нийт 653,008.7 сая төгрөг, үүнээс төсөвт байгууллагын урсгал зардалд 9,651.3 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 143,915.3 сая төгрөг, гадаадын зээл тусламжаар санхүүжих зардалд 499,442.1 сая төгрөг баталсан байна.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 632,333.0 сая төгрөг буюу 96.8 хувь байна. Үүнээс төсөвт байгууллага болон, төслийн урсгал зардалд 29,139.8 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвөөс 266.1 сая төгрөгөөр, хөрөнгийн зардалд 603,193.1 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвөөс 13,923.6 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлын ерөнхий ангиллаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамж зардал 306.1 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр, арга хэмжээгээр биелэлтийг гаргаагүй байсныг аудитын явцад гаргуулав.

Мөн нэмэлт санхүүжилтээр 13,913.1 сая төгрөг төвлөрүүлснээс зардалд 9,313.8 сая төгрөг, хөрөнгийн зардалд 101.2 сая төгрөгийг зарцуулж 4,498.1 сая төгрөгийг зарцуулаагүй байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Зам, тээврийн хөгжлийн сайд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Зам, тээврийн хөгжлийн яам өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

- Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр)
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (хагас, бүтэн жилээр, улирал бүр, сар бүр)
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (тухай бүр)
- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (хагас, бүтэн жилээр)
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (хагас, бүтэн жилээр)
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр)
- Санхүүгийн тайлан (хагас, бүтэн жилээр)
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (бүтэн жилээр)
- Байгууллагын батлагдсан төсөв (бүтэн жилээр) зэрэг болно.



Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Зам, тээврийн хөгжлийн яамтай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

3.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 34 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 29 нарийвчилсан болон хяналтын горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

3.9 Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

3.9.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал


Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 2 төсөвт байгууллага, 46 төрийн өмчит үйлдвэрийн газар, 1 төсвийн төвлөрүүлэн захирагч, 1 төслийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 52,166.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 29,576.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 914.4 сая төгрөгийн төлбөрийн 6 акт тогтоож, 15,665.2 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага, 6,010.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 86 зөвлөмж хүргүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад арга хэмжээ авч ажиллах, харьяа газруудын акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллах зөвлөмж хүргүүлэх

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн материаллаг алдаа, зөрчлийг дурдвал. Үүнд:

- Монголын төмөр зам ТӨХК-ийн санхүүгийн тайланд БНХАУ-ын Засгийн газраас олгосон 300.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн хүрээнд 85 хувийг, Монгол Улсын Засгийн газраас 15 хувийг тус тус санхүүжүүлэхээр 2012 онд Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хэсгийн парк шинэчлэл ба нийлүүлэлт төсөлд 64.3 сая ам.долларын дамжуулан зээлийн гэрээ байгуулсан. Уг төслийн нэг хэсэг болох Төмөр замын хөдөлгөх бүрэлдэхүүн хэсгийн зогсоолыг өргөтгөх төслийн 35.7 сая ам.доллар буюу 86,629.5 сая төгрөгийн зээлийн хуримтлагдсан хүүгийн 9,219.9 сая төгрөгийг төлөөгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээ байгуулаагүй.

Энэ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор дамжуулан зээлдүүлэх тохиолдолд тухайн салбар, эсхүл орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь дэд зээлдэгчийн үүргийг гүйцэтгэх бөгөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчийн хооронд гурвалсан гэрээ байгуулна", мөн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-д "эцсийн зээлдэгч дараах үүрэгтэй" 31.3.2-д "дамжуулан зээлдүүлэх зээлийн үндсэн, хүүгийн болон бусад төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөх. Тэгж заасныг тус тус зөрчсөн байна.



Шийдвэрлэсэн нь: Өрийн удирдлагын тухай хуулийн 31.3, 31.3.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэн дамжуулан зээлийн гурвалсан гэрээ байгуулах, зээлийн хүүгийн өглөгийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах талаар Монголын төмөр зам ТӨХК-ий санхүүгийн аудитын тайланд тусгаж албан шаардлага өгсөн.

- МИАТ ТӨХК нь хүчинтэй хугацаа дууссан зорчигчийн тасалбарын бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тусгайлсан дүрэм, журмаар зохицуулаагүйгээс олон жилийн туршид санхүүгийн тайланд урьдчилж орсон орлогоор хуримтлуулан бүртгэсэн.

Энэ нь НББОУС 8(10)-д "Ажил гүйлгээ, ... нөхцөл байдлыг бүртгэхэд тусгайлан хэрэглэх СТОУС байхгүй тохиолдолд удирдлага ... өөрсдийн мэргэжлийн шийдлийг ашиглана", 8(12)-д "... мэргэжлийн шийдлийг гаргахдаа удирдлага ... хүлээн зөвшөөрсөн салбарын практик туршлагыг мөн адил харгалзан үзэх хэрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: СТОУС-ын болон IATA-аас гаргасан "IATA General Conditions of Carriage (Passenger and Baggage)"-н 11.6, 11.6.1 дэх заалтуудыг баримтлан хүчингүй билетийн мөнгийг орлогод тооцох бодлого, дүрэм, журмыг боловсруулж мөрдөж санхүүгийн тайланд хүчингүй билетийн урьдчилж орсон орлогыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх талаар МИАТ ТӨХК-ийн санхүүгийн аудитын тайланд зөвлөмжөөр өгсөн.

- Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн тайланд 11 байгууллагатай холбоотой гэрээний хугацаа дууссан, тооцоо нийлсэн актгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2,047.6 сая төгрөгийг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн, 4 байгууллагатай холбоотой тооцоо нийлсэн актгүй 128.6 сая төгрөгийн авлага тус тус байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй хөрөнгө оруулалтын ажлуудыг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага, авлагыг тооцоо нийлж баталгаажуулж байх зөвлөмжийг ИНЕГ-ын үйлдвэрлэл нисэх хөдөлгөөний албаны санхүүгийн аудитаар өгсөн.


3.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд нэгтгэдэг 2 сан, хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлан, 7 төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайланд түүврийн аудит хийсэн бөгөөд аудитын явцад нийт 85,549.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 83,616.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын явцад залруулж, 288.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 1,644.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Эдгээр зөвлөмж, албан шаардлага, актыг нэгтгэж, ажлын баримт материалд хавсарган Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төслийн 57,061.8 сая төгрөгийн хөрөнгөтэй санхүүгийн тайланг төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулж нэгтгээгүй, аудитын явцад санхүүгийн байдлын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайланг баталгаажуулж ирүүлээгүй, санхүүгийн тайлангийн бусад тайлан тодруулгыг ирүүлээгүй

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу батлагдсан маягт, тодруулгаар санхүүгийн тайланг бэлтгээгүй, Өрийн удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.3-д "төсөл, арга



хэмжээний хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтмол хүргүүлэх, эдгээр тайлан, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангуулах," гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Өрийн удирдлагын тухай хуулийн 31.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд баталгаажсан санхүүгийн тайлан нэгтгэж байх, аудитын хугацаанд залруулан авсан.

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд хөрөнгө оруулалтын ажлын барьцаа хөрөнгийн харилцах дансанд байршиж байгаа 2008 он буюу түүнээс өмнө үүссэн 288.9 сая төгрөгийн 41 аж ахуйн нэгж байгууллагад өгөх хөөн хэлэлцэх хугацаа дууссан өр төлбөр бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" мөн хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6, Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байх, улсын төсвийн орлого болгох, акт тогтоохоор шийдвэрлэв.

Тус яам нь салбарын онцлогт нийцсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргах бодлогын баримт бичиггүй байгаа ба Авто зам засвар арчлалт ТӨЖК-иудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС, Сангийн сайдын баталсан бодлого аргачлал журамтай нийцэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" мөн хуулийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй байна.


Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2, 20.2.3 дахь заалтуудыг мөрдөн ажиллаж НБББББ-ийг сайжруулах арга хэмжээ авч ажиллах, салбарын бүртгэлийн онцлогийг тусгах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд 55.7 сая төгрөгийн дансны үнэтэй төлбөр хураах цэгийн нураасан байр, 2010 оноос элэгдлийн хугацаа дууссан ашиглагдахгүй байгаа 53.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэлтэй байна.

Энэ нь УСНББОУС 17-ын 82 дугаар зүйл Үл хүлээн зөвшөөрөлт Үндсэн хөрөнгийн зүйлийн дансны үнийг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрөх буюу данснаас хасна (b) "Хөрөнгийг данснаас хасах буюу борлуулах эсвэл түүний ашиглалтаас ирээдүй эдийн засгийн үр өгөөж, үйлчилгээний чадавхи хүртэхгүй болсон үед" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ашиглагдахгүй болсон үндсэн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн, хууль дүрэм журам стандартын дагуу шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд 2006-2008 онд үүссэн 24 харилцагч байгууллагатай холбоотой тооцоо нийлсэн актгүй 1,078.1 сая төгрөг, шүүхийн шатанд



байгаа 322.9 сая төгрөг, шүүхийн шийдвэртэй боловч барагдаагүй 134.0 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах, авлагыг барагдуулах талаа арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Сангийн сайдын 415 дугаар журмын дагуу харьяа газруудын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ажлын үр дүнд бий болсон дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 325,191.7 сая төгрөгийг эргэлтийн хөрөнгийн бусад хэсэгт шилжүүлэн бүртгэсэн, улсын чанартай зам гүүрийн барилга байгууламжийн тооллогын үр дүнг програм хангамжид хөрөнгийг хуримтлуулж залруулан бүртгэхдээ 22,654.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг илүү бүртгэсэн, давхардсан гүйлгээ болон бусад ажил гүйлгээгээр 3,533.5 сая төгрөгөөр тайлангийн үеийн үр дүнг илүү илэрхийлж 19,642.1 сая төгрөгөөр нийт хөрөнгийг дутуу илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах," гэж тус тус заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийв.

Барилга, хот байгуулалтын яамны санхүүгийн тайланд бүртгэлтэй 6,912.7 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн нэгтгэсэн тайлангаас хасч залруулга хийхдээ анхан шатны баримт болон нотлох баримт хавсаргаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтөлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийв.

3.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

БНХАУ-ын Засгийн газраас олгосон 300.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн хүрээнд 85 хувийг, Монгол Улсын Засгийн газраас 15 хувийг санхүүжүүлэн хэрэгжүүлсэн Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хэсгийн парк шинэчлэл ба нийлүүлэлт төслийн 2012 онд байгуулсан 64.3 сая ам.доллараар байгуулсан дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ, эргэн төлөлт, бүртгэл тайлагналтай холбоотой дараах анхаарал татах асуудлууд байна. Үүнд:

- Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчийн хооронд гурвалсан гэрээ байгуулаагүй;
- Дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлтийн хуваарийг хийгээгүй;
- Тус дамжуулан зээлдүүлэх гэрээний бүрэлдэхүүн хэсэг Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төслийн 28.6 сая ам.доллар буюу 69,387.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн хуримтлагдсан өглөг 5,035.6 сая төгрөг нийт 74,423.4 сая төгрөгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй;
- 2012 оноос хойш хүүгийн өглөгийг төлж барагдуулаагүй зээлийн хуримтлагдсан хүүг 14,381. сая төгрөгт хүрсэн ба Монгол Улсын Засгийн газар 2011-2017 оны үндсэн төлбөрт санхүүжүүлэгч талд 5.2 сая ам.доллар буюу 9,994.3 сая төгрөгийг өглөө;
- Тус төслийн хөрөнгөөс 28.6 сая ам.доллар буюу 57,061.8 сая төгрөгийн 6 нэр төрлийн 65 ширхэг төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний тоног төхөөрөмжийг

ашиглахгүй байгаа ба хадгалалт хамгаалалтын зардалд нийт 30.9 сая төгрөгийг зарцуулсан;

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны А-1/617 дугаар албан бичгээр Монголын төмөр зам ТӨХК-ийг тус хөрөнгийг санхүүгийн тайландаа бүртгэснээр цаашид хэрхэн ашиглах нь тодорхойгүй, компаний зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгө гэж үзэх үндэслэлгүй, алдагдалд оруулах эрсдэлтэй тул бүртгэхгүй байх чиглэл өгсөн байна.

Дээрх асуудлууд нь тайланд хугацаанд хамаарахгүй өмнөх үеийн бүртгэл, тайлагнал үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн тул өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийх аудитаар анхаарч үзэх нь зүйтэй байна.

Мөн харьяа Төрийн өмчит газруудын санхүүгийн тайлангийн аудитад дараах анхаарал татах асуудлууд байна. Үүнд:

- Иргэний нисэхийн ерөнхий газар мэргэжлийн сургалтад зориулж 2017 оны 8 дугаар сард Гүрэн дээд сургуультай 180 ажилтанд сургалт зохион байгуулахаар сургалтын төлбөрт нэг ажилтанд дунджаар 2-3 сая төгрөгийн төлбөр төлөхөөр нийт 640.0 сая төгрөгийн гэрээг хийсэн боловч гэрээний хугацаа дууссан байхад гүйцэтгэлээр 160 хүн сургалтад хамрагдсан ба үүний 7 ажилтан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гэрчилгээ, 133 ажилтан Гүрэн дээд сургуулийн гэрчилгээ авсан нь гэрээнд заасан "олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификат бүхий сургалт" гэсэн шалгуур хангагдаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байсан.
- Монголын иргэний агаарын тээврийн дотоод аудитын алба 2017 онд гадаад дахь 5 төлөөлөгчийн газарт 8 удаагийн хяналт шалгалт хийж 142.3 сая төгрөгийн зөрчлийг илрүүлсэн байна. Үүнээс Токио дахь төлөөлөгчийн газрын 4 билет бичигч нийт 126.7 сая төгрөгийн борлуулалтын орлогын мөнгийг тушаалгүй хувьдаа ашиглаж байсныг илрүүлж тайлант оны байдлаар 26.6 сая төгрөгийг төлүүлсэн байна.

3.11 ЗАВСРЫН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД


Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын завсрын аудитаар дараах асуудлуудыг авч үзэх болно. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын техник хяналтын зардлын төвлөрүүлэлт, зарцуулалт, Авто замын норм нормативын сангийн хөрөнгийн захиран зарцуулалт, Авто замын сангийн давсан орлогын зарцуулалт;
- Ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан журам, болон бусад холбогдох хууль, журмын дагуу ажиллаж байгаа эсэх;
- Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд олон жил болсон авлага, өр төлбөр;
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ болон гадаадын зээл тусламжаар санхүүжсэн ашиглагдахгүй байгаа хөрөнгө

3.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 63 санхүүгийн тайлангаас 45 санхүүгийн тайланд аудитын дүгнэлт өгсөн, төсөл, сан, зардлын дансны 14 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан, 1 санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн, 3 төслийн санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй байна. Үүнээс 42 санхүүгийн тайлан зөрчилгүй, 3 санхүүгийн тайлан хязгаарлалттай санал дүгнэлт авсан байна.П

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,377,16.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, алдааны залруулгатай холбоотой 113,192.9 сая алдаа, зөрчлийг залруулж, 1,203.2 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 15,665.2 сая төгрөгийн 18 албан



шаардлага, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 7,654.5 сая төгрөгийн 90 зөвлөмж хүргүүлээ.

3.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 652,321.3 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 149,103.2 сая төгрөгийн алдааг залруулж, 502,101.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,116.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 зөвлөмж өгсөн.

Үүнээс бүртгэл тайлагнал болон төрийн өмчит үйлдвэрийн газруудын зорилтот түвшин, харьяа байгууллагуудын зөрчилтэй холбоотой өгсөн зөвлөмж 88 хувь, хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгөтэй холбоотой өр төлбөрийг барагдуулахаар өгсөн зөвлөмж 40 хувьтай, 5 заалттай 1 албан шаардлага өгснөөс төслийн хөрөнгийн бүртгэл тайлагналыг залруулах 100 хувь, хэрэгжиж дууссан төслийг үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэх 866.3 сая төгрөгийг төвлөрүүлж 100 хувь, аудит хийгдээгүй төслийн тайлан нэгтгэхгүй байх 50 хувь, хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн өр төлбөрийг шийдвэрлэх 60 хувийн тус тус биелэлттэй нийт албан шаардлага 82.0 хувийн биелэлттэй байна.

3.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлогоор сонгов.

Үр дүнгийн тайлангийн орлого, зардлаар материаллаг байдлын суурийг авахад ТӨҮГ-уудын борлуулсан бүтээгдэхүүний өртөг 396.1 тэрбум төгрөгийг нийт орлогоос хасаж цэвэр дүнгээр тайлагнасан, нийт хөрөнгө, цэвэр хөрөнгөөс тооцоход их байгаа тул мөнгөн гүйлгээний тайлангийн нийт орлого 1,416,536.1 сая төгрөгийн 1 хувь буюу 14,165.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан, төсвийн төвлөрүүлэн захирагч, төрийн өмчит үйлдвэрийн газруудын санхүүгийн тайлангийн аудитаар 20,951.7 сая төгрөгийн акт, албан шаардлага, зөвлөмж өгсөн зэргээс шалтгаалан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланг төлөвлөлтийн үед дунд гэж тодорхойлсон тул материаллаг байдлын хувийг 1 хувиар сонголоо.


Гүйцэтгэлийн үед материаллаг байдалд өөрчлөлт ороогүй ба шинж чанар, орчин нөхцөлийн хувьд материаллаг шинжтэй зүйл байж болзошгүй гэж үзсэн ба гүйцэтгэлээр шинж чанар, орчин нөхцөлийн хувь материаллаг шинжтэй алдаа, зөрчил илэрсэн болно.

3.15 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

3.16 Аудитын үр өгөөж

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 1,203.2 сая төгрөгийн үр өгөөжийн тооцооллыг хийж, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагаар баталгаажуулсан болно



4 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Зам, тээврийн хөгжлийн сайдын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.



4.1 Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчлийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	---------------------------

ҮАГ-ын ажиглалт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын 2 төсөвт байгууллага, 46 төрийн өмчит үйлдвэрийн газар, 1 төсвийн төвлөрүүлэн захирагч, 1 төслийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 52,166.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 29,576.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 914.4 сая төгрөгийн төлбөрийн 6 акт тогтоож, 15,665.2 сая төгрөгийн зөрчилд 18 албан шаардлага, 6,010.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 86 зөвлөмж хүргүүлсэн байна.

Эрсдэлүүд:

Бүртгэлээр тавих хяналт сулрах, хууль, дүрэм, журам мөрдөгдөхгүй байх, үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад арга хэмжээ авч ажиллах, харьяа газруудын акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллах зөвлөмж хүргүүлэх

Биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.

4.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--	---------------------------

ҮАГ-ын ажиглалт:

Тус яам нь салбарын онцлогт нийцсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргах бодлогын баримт бичиггүй байгаа ба Авто зам засвар арчлалт ТӨХК-иудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь СТОУС, Сангийн сайдын баталсан бодлого аргачлал журамтай нийцэхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль, дүрэм журам мөрдөгдөхгүй байх, толилуулга ба тодруулга, үнэн зөв байх батламж мэдэгдэл хангахгүй байна.


ҮАГ-ын зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2, 20.2.3 дахь заалтуудыг мөрдөн ажиллаж НБББББ-ийг сайжруулах арга хэмжээ авч ажиллах, салбарын бүртгэлийн онцлогийг тусгах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.



4.3 Үндсэн хөрөнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
-----------------------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт:

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд 55.7 сая төгрөгийн дансны үнэтэй төлбөр хураах цэгийн нураасан байр, 2010 оноос элэгдлийн хугацаа дууссан ашиглагдахгүй байгаа 53.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэлтэй байна

Энэ ньУСНББОУС 17-ын 82 дугаар зүйл Үл хүлээн зөвшөөрөлт Үндсэн хөрөнгийн зүйлийн дансны үнийг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрөх буюу данснаас хасна (b) "Хөрөнгийг данснаас хасах буюу борлуулах эсвэл түүний ашиглалтаас ирээдүй эдийн засгийн үр өгөөж, үйлчилгээний чадавхи хүртэхгүй болсон үед" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд:

Найдваргүй, олон жил болсон авлага нэмэгдэх, төсвийн зохистой удирдлага хэрэгжихгүй байх, эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэл хангахгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж:

Ашиглагдахгүй болсон үндсэн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн, хууль дүрэм журам стандартын дагуу шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.

4.4 Авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--	---------------------------

ҮАГ-ын ажиглалт:

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд 2006-2008 онд үүссэн 24 харилцагч байгууллагатай холбоотой тооцоо нийлсэн актгүй 1,078.1 сая төгрөг, шүүхийн шатанд байгаа 322.9 сая төгрөг, шүүхийн шийдвэртэй боловч барагдаагүй 134.0 сая төгрөгийн авлага нийт 1,535.5 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, эр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна

Эрсдэлүүд:

Найдваргүй, олон жил болсон авлага нэмэгдэх, төсвийн зохистой удирдлага хэрэгжихгүй байх


ҮАГ-ын зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах, авлагыг барагдуулах талаа арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг байгууллагын асуудлын бүртгэлээр хүлээн зөвшөөрсөн болно.



5 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

5.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	104,683,367.9	143,327,605.1
Авлага	92,455,140.3	95,091,252.3
Урьдчилж төлсөн зардал	556,949,039.4	202,500,008.5
Бараа материал	76,029,489.0	498,228,322.2
Нөөцийн хөрөнгө	920.9	803.9
Бусад эргэлтийн хөрөнгө	867,500,360.4	646,908,203.8
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,697,618,317.9	1,586,056,195.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
Урт хугацаат хөрөнгө оруулалт	190,192.0	190,192.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,248,297,680.8	3,678,730,626.3
Газар	10,676.4	10,676.4
Биет хөрөнгө	3,221,851,932.3	3,645,074,152.0
Биет бус хөрөнгө	26,435,072.1	33,645,797.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,248,487,872.8	3,678,920,818.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,946,106,190.6	5,264,977,014.0
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Өглөг	72,464,882.6	85,315,049.4
Богино хугацаат зээлийн өглөг	64,351,787.4	85,797,909.7
Урьдчилж орсон орлого	47,593,868.6	47,030,483.7
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	184,410,538.5	218,143,442.8
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Урт хугацаат зээл	290,947,710.4	231,863,489.9
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	290,947,710.4	231,863,489.9
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	475,358,248.9	450,006,932.7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ		
Засгийн газрын хувь оролцоо	4,470,747,941.7	4,814,970,081.3
Хуримтлагдсан үр дүн	3,347,151,157.2	3,574,146,970.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	130,874,878.9	131,034,088.9
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	4,470,747,941.7	4,814,970,081.3
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН НИЙТ ДҮН	4,946,106,190.6	5,264,977,014.0

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

5.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,348,555,925.1	962,118,595.3
ТАТВАРЫН ОРЛОГО		
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	814,293,795.9	821,291,766.3
Нийтлэг татварын бус орлого	812,358,504.7	819,852,651.2
Хөрөнгийн орлого		4,090.9
Тусламжийн орлого		1,435,024.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	534,262,129.2	140,826,829.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	359,410,341.7	400,333,582.7
УРСГАЛ ЗАРДАЛ	333,628,926.8	382,505,078.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	328,180,462.3	378,385,552.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,735,330.1	4,496,365.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	298,209.8	478,757.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190,871.3	233,868.7
Хангамж, бараа материалын зардал	143,489.9	225,262.0
Нормативт зардал	343.6	5,835.5
Эд хогшил, урсгал засварын зардал	42,200.4	30,820.8
Томилолт, зочны зардал	136,558.3	187,451.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	197,946,099.6	246,781,906.1
Бараа үйлчилгээний бусад зардал	126,687,359.2	125,945,284.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,448,464.5	4,119,526.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,781,414.9	17,828,503.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	989,145,583.4	561,785,012.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	44,439,474.5	7,977,588.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	60,307,478.5	172,653,547.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	973,277,579.4	397,109,053.1



5.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)

Тайлангийн үзүүлэлт	2016 оны 12 дугаар сарын 31	2017 оны 12 дугаар сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,337,136,643.1	1,402,054,307.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	810,138,677.2	1,258,490,912.1
Нийтлэг татварын бус орлого	808,203,385.9	1,257,055,887.9
Хөрөнгийн орлого	0.0	0.0
Тусламжийн орлого	1,935,291.3	1,435,024.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	526,997,965.9	143,563,394.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	518,830,788.6	733,950,061.0
УРСГАЛ ЗАРДАЛ	518,830,788.6	733,950,061.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	391,004,209.0	573,326,038.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	94,562,677.5	109,432,876.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,773,892.8	21,418,089.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,230,074.5	8,342,922.5
Хангамж, бараа материалын зардал	82,797,848.1	116,223,991.8
Нормативт зардал	377,984.8	157,242.3
Эд хогшил, урсгал засварын зардал	3,268,402.1	3,795,317.3
Томилолт, зочны зардал	1,138,067.3	1,660,640.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	181,519,269.0	308,308,229.8
Бараа үйлчилгээний бусад зардал	8,335,992.8	3,986,728.7
ТАТААС	0.0	157,105.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,826,579.6	160,466,917.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	818,305,854.5	668,104,245.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	16,562,622.6	3,621,663.5
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	770,823,427.1	596,205,218.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	770,823,427.1	596,205,218.0
Дотоод эх үүсвэрээр	770,823,427.1	596,205,218.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(754,260,804.5)	(592,583,554.5)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(28,949,828.3)	(36,876,454.3)
Бусад эх үүсвэр	2,522,166.7	7,209,892.2
Гадаад зээлийн үндсэн төлбөр	0.0	0.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	31,471,995.0	44,086,346.5
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	35,095,221.7	38,644,237.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	69,588,146.1	104,683,367.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	104,683,367.9	143,327,605.1

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

5.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мян.төг)

Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,442,652,101.0		3,442,652,101.0
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	54,152,057.5		54,152,057.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,496,804,158.5		3,496,804,158.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	666,203.8		666,203.8
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт			
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0		0.0
Тайлант үеийн үр дүн	973,277,579.4		973,277,579.4
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,470,747,941.7		4,470,747,941.7
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,470,747,941.7		4,470,747,941.7
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	(144,365,713.8)		(144,365,713.8)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,326,382,228.0		4,326,382,228.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт			
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	5,827,704.6		5,827,704.6
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	85,651,095.7		85,651,095.7
Тайлант үеийн үр дүн	397,109,053.0		397,109,053.1
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,814,970,081.3		4,814,970,081.3



5.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан


Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		104,683,367,880.84		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	653,008,717,200.00	632,333,012,526.66	20,675,704,673.34	96.8
УРСГАЛ ЗАРДАЛ	29,405,954,400.00	29,139,878,932.21	266,075,467.79	99.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,895,256,800.00	28,693,453,790.21	201,803,009.79	99.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,573,545,000.00	6,335,548,980.99	237,996,019.01	96.4
Үндсэн цалин	4,969,031,000.00	4,811,114,664.78	157,916,335.22	96.8
Нэмэгдэл	1,231,835,100.00	1,168,664,616.21	63,170,483.79	94.9
Унаа хоолны хөнгөлөлт	372,678,900.00	355,769,700.00	16,909,200.00	95.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	725,887,000.00	698,034,463.09	27,852,536.91	96.2
Тэтгэврийн даатгал	461,928,200.00	444,671,073.20	17,257,126.80	96.3
Тэтгэмжийн даатгал	61,592,600.00	62,115,455.05	(522,855.05)	100.8
ҮОМШӨ-ний даатгал	56,138,600.00	51,493,031.53	4,645,568.47	91.7
Ажилгүйдлийн даатгал	14,248,100.00	13,183,493.70	1,064,606.30	92.5
Эрүүл мэндийн даатгал	131,979,500.00	126,571,409.61	5,408,090.39	95.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	379,218,400.00	319,716,247.00	59,502,153.00	84.3
Гэрэл, цахилгаан	66,596,900.00	58,816,647.70	7,780,252.30	88.3
Түлш, халаалт	51,347,500.00	40,667,396.16	10,680,103.84	79.2
Цэвэр, бохир ус	19,800,000.00	30,434,603.14	(10,634,603.14)	153.7
Байрны түрээс	241,474,000.00	189,797,600.00	51,676,400.00	78.6
Хангамж, бараа материалын зардал	275,337,500.00	220,351,466.17	54,986,033.83	80.0
Бичиг хэрэг	76,604,300.00	62,701,352.34	13,902,947.66	81.9
Тээвэр, шатахуун	106,742,600.00	78,953,886.97	27,788,713.03	74.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	41,131,700.00	40,354,625.22	777,074.78	98.1
Ном хэвлэл	12,850,400.00	130,000.00	12,720,400.00	1.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,008,500.00	38,211,601.64	(203,101.64)	100.5
Нормативт зардал	28,327,500.00	25,398,500.00	2,929,000.00	89.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,327,500.00	25,398,500.00	2,929,000.00	89.7
Эд хогшил, урсгал засварын зардал	82,766,700.00	77,468,262.00	5,298,438.00	93.6
Багаж, техник, хэрэгсэл	21,701,100.00	19,816,872.00	1,884,228.00	91.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,980,000.00	8,480,209.00	(2,500,209.00)	141.8
Урсгал засвар	55,085,600.00	49,171,181.00	5,914,419.00	89.3
Томилт, зочны зардал	220,718,900.00	198,609,280.00	22,109,620.00	90.0
Дотоод албан томилт	220,718,900.00	198,609,280.00	22,109,620.00	90.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,340,848,100.00	20,646,919,613.39	(306,071,513.39)	101.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,993,966,500.00	20,301,687,716.14	(307,721,216.14)	101.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	21,285,000.00	21,231,580.00	53,420.00	99.7
Даатгалын үйлчилгээ	15,515,900.00	14,881,150.00	634,750.00	95.9
Тээврийн хэрэгслийн татвар	1,128,400.00	719,200.00	409,200.00	63.7

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Тээврийн хэрэгслийн оношлогоо	591,600.00	522,800.00	68,800.00	88.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	62,293,800.00	62,205,962.25	87,837.75	99.9
Газрын төлбөр	7,248,300.00	6,854,500.00	393,800.00	94.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,395,000.00	1,393,300.00	1,700.00	99.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	237,423,600.00	237,423,405.00	195.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	268,607,700.00	171,406,977.57	97,200,722.43	63.8
Бараа үйлчилгээний бусад зардал	183,249,800.00	86,056,977.57	97,192,822.43	47.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	85,357,900.00	85,350,000.00	7,900.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	510,697,600.00	446,425,142.00	64,272,458.00	87.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	167,147,000.00	155,867,000.00	11,280,000.00	93.3
Засгийн газрын гадаад шилжүүлэг	167,147,000.00	155,867,000.00	11,280,000.00	93.3
Бусад урсгал шилжүүлэг	343,550,600.00	290,558,142.00	52,992,458.00	84.6
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	58,884,000.00	58,828,110.00	55,890.00	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	169,166,600.00	149,530,032.00	19,636,568.00	88.4
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	115,500,000.00	82,200,000.00	33,300,000.00	71.2
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	617,116,762,800.00	603,193,133,594.45	13,923,629,205.55	97.7
Барилга байгууламж	588,692,787,400.00	575,283,486,867.23	13,409,300,532.77	97.7
Их засвар	24,500,000,000.00	24,490,100,334.00	9,899,666.00	100.0
Тоног төхөөрөмж	3,923,975,400.00	3,419,546,393.22	504,429,006.78	87.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	6,486,000,000.00	0.00	6,486,000,000.00	0.0
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	6,486,000,000.00	0	6,486,000,000.00	0.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	653,008,717,200.00	633,235,629,594.30	19,773,087,605.70	97.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	151,665,825,100.00	134,103,417,460.08	17,562,407,639.92	88.4
Улсын төсвөөс санхүүжих	151,665,825,100.00	134,103,417,460.08	17,562,407,639.92	88.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,338,636,100.00	497,697,187,887.53	2,641,448,212.47	99.5
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,900,762,300.00	2,508,858,324.00	(608,096,024.00)	132.0
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	498,437,873,800.00	495,188,329,563.53	3,249,544,236.47	99.3
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	1,004,256,000.00	1,435,024,246.69	(430,768,246.69)	142.9
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	1,004,256,000.00	1,435,024,246.69	(430,768,246.69)	142.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	143,327,605,090.86	(143,327,605,090.86)	
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт	0	37,741,620,142.38	(37,741,620,142.38)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	4	0	100.0
Төсвийн байгууллага	4	4	0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	774	830	-56	107.2
Удирдах ажилтан	28	31	-3	110.7
Гүйцэтгэх ажилтан	256	256	0	100.0
Үйлчлэх ажилтан	103	128	-25	124.3
Гэрээт ажилтан	387	415	-28	107.2



5.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны 12 сарын 31
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,415,052,703.0
УРСГАЛ ЗАРДАЛ	9,313,869,932.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,619,928,683.0
Бараа үйлчилгээний бусад зардал	8,619,928,683.0
Бараа үйлчилгээний бусад зардал	8,619,928,683.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	693,941,249.0
Бусад урсгал шилжүүлэг	637,946,015.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	637,946,015.0
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,995,234.0
Төвлөрүүлэх шилжүүлэг	55,995,234.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	101,182,771.0
Дотоод эх үүсвэрээр	101,182,771.0
Их засвар	101,182,771.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,293,023.3
Нэмэлт санхүүжилтийн орлого	13,913,116,226.0
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	4,910,989,180.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,504,063,523.0
Төсвийн урамшуулал	4,498,063,523.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	4,498,063,523.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,498,063,523.0

